

## ГАДААД ХУДАЛДААНД ТАРИФЫН БУС ЗОХИЦУУЛАЛТЫГ АШИГЛАХ НЬ

*П. Лхамсүрэн<sup>1</sup>*

**М**онгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжээд 20 орчим жилийн хугацаа өнгөрч байна. Нийгмийн нэг системээс нөгөөд шилжих шилжилтийн энэ үед манай улсын эдийн засгийн бүхий л салбарт, тэр дундаа гадаад худалдааны салбарт ихээхэн өөрчлөлт гарсан ба худалдааны түншүүдийн тоо өсч, хараат бус, харилцан ашигтай худалдааны бодлого хэрэгжүүлэх боломжтой болсон. 1997 онд Монгол улс Дэлхийн худалдааны байгууллага(ДХБ)-д элсэн орсон нь тус улсын гадаад худалдааг либералчлах, ДХБ-ын гишүүн 153 улстай худалдаагаа өргөжүүлэх таатай боломж олгож байна.

Хэдийгээр худалдааны түнш орнуудын тоо нэмэгдсэн ч дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн харьцангуй сул хөгжил, хөрш орнуудын гадаад худалдаанд эзлэх байр суурь зэргийг харахад дотоодын эдийн засгийн гадаад зах зээлээс хамаарах хамаарал их, үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд худалдааны бодлогыг үр ашигтай чиглүүлэх шаардлага өндөр байгаа юм. Түүнчлэн газар зүйн байрлалын онцлог, хөрш орнуудын байршил нь гадаад худалдааны тээвэрлэлтийн өртөг зардлыг өсгөж улмаар худалдааг үр ашигтай явуулахад хязгаарлалт болж байна.

Монгол улс ДХБ-д элсэхдээ авсан үүрэг амлалтын хүрээнд тарифын түвшингээ бууруулсан бөгөөд одоогийн байдлаар дунджаар 5%-тай байгаа ба энэ нь худалдаагаа чөлөөлсөн томоохон алхам юм. Олон улсын байгууллага(ОУБ), олон талт гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу тарифын бус арга хэмжээний үйлчлэх хүрээг багасгах, нэр төрлийг нь бууруулах алхам хийж 1993 онд үйлчилж байсан УИХ-ын тогтоолд тусгагдсан тарифын бус арга хэмжээг 1998 оны тогтоолоор шинэчлэн тогтоосон. Манай улс хэдийгээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай боловч эдийн засгаа түргэн хөгжүүлэхийн тулд олон талт гэрээнд нийцсэн зохицуулалтыг бүтээлчээр ашиглах, худалдааны тэнцлээ сайжруулах, улмаар үйлдвэрлэлээ хөгжүүлэх явдал чухал зорилго болох нь зайлшгүй. Дэлхийн ихэнх улс орнууд тарифын болон тарифын бус зохицуулалтыг хослуулан хэрэглэдэг ба энэ нь тарифын зохицуулалтыг дангаар ашиглахад:

- хүссэн үр дүндээ хүрдэггүй;
- уян хатан бус;
- олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг нь тарифийн зохицуулалтын хувь хэмжээг хязгаарладаг;
- манай улсын хувьд тарифын бус зохицуулалтыг эдийн засгаа хөгжүүлэх чиглэлд ашиглаж байгаа туршлага хомс байгааг харгалзан энэ чиглэлд явуулах судалгааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Өнөө үед хүлээн зөвшөөрөгдсөн Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн 5 хэсэг, ОУБ, ЮНКТАД, ОУХ-ны танхимд нэгдсэн тарифын бус хязгаарлалтын 600 гаруй тодорхой төрлүүд бий.


<sup>1</sup> МУИС-ийн ОУХС-ийн багш

### Монгол улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал

Монгол улс нь 1564.1 мянган км<sup>2</sup> газар нутагтай, 2628,84<sup>2</sup> мянган хүн амтай бөгөөд хүн амын нягтрал хамгийн бага орнуудын нэг юм. Нэг хүнд ногдох ДНБ 2007 онд ОУВС-ын тооцоолсноор 1489 ам.доллар ба энэ нь дэлхийд 121-д, Дэлхийн банкны тооцоолсноор 1491 ам.доллар ба энэ нь дэлхийд 115-д орох үзүүлэлт аж<sup>3</sup>.

Монгол улсын эдийн засагт цөөн тооны салбар зонхилох үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь уул уурхай, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр хязгаарлагддаг. 1990 оноос эдийн засаг, нийгмийн өөрчлөн шинэчлэлтийг хийж өмчийн эзэмшилд ихээхэн өөрчлөлт хийж чадсан боловч шилжилтийн үе үргэлжилсээр үйлдвэрлэл, тэр дундаа боловсруулах үйлдвэрлэлийн салбар хөгжихгүй байна. Монголын эдийн засаг шилжилтийн эхэн үед огцом уналтанд орсон бөгөөд дараа нь зах зээлийн эдийн засагт чиглэсэн шинэчлэлийн хүрээнд бүтээмжийн өсөлт гарч, үүний үр дүнд аажмаар сэргэх эхлэл тавигдсан гэж ихэнх судлаачид үздэг. (Зураг 1)

Зураг 1. Эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл

1990-1993 онд буюу шилжилтийн эхний жилүүдэд эдийн засгийн уналт үргэлжилж 1994 оноос өсч эхлэн 2001 он гэхэд 1991 оны түвшиндээ буцаж хүрсэн.


Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханшийн өсөлт сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын өсөлтгөд ихээхэн нөлөөлсөн бөгөөд харин экспортын орлогоос хамаарах импортын мэдрэмж харьцангуй өндөр буюу 1,42 байгаа нь импортыг орлуулах дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн хөгжилтөд сөргөөр нөлөөлсөн байх талтай.

Хугацааны дунджаар аваад үзэхэд хамгийн их хазайлттай нь уул уурхайн салбар буюу 120803,1 сая төгрөг, хамгийн бага хазайлттай нь 19355,22 сая төгрөг буюу боловсруулах үйлдвэрлэлийн салбар байна. Товчхондоо МҮ-ын эдийн засаг гадаад зах зээлээс хүчтэй хамааралтай эмзэг эдийн засгийн бүтэцтэй болсон байна.

<sup>2</sup> [http://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_countries\\_by\\_GDP\\_growth](http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_GDP_growth)

<sup>3</sup> [http://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_countries\\_by\\_GDP\\_\(nominal\)\\_per\\_capita](http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_GDP_(nominal)_per_capita)

### Зураг 2. Салбарын бүтцийн өөрчлөлт, 1995 оны үнээр, сая.төг




Эх үүсвэр: МҮ-ын статистикийн эмхэтгэл

### Монгол улсын гадаад худалдаа

Монгол улсын газар зүйн байрлалын онцлог, дэд бүтцийн сул хөгжил, далайд гарах шууд гарцгүй зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр импортын барааны тээвэрлэлтийн зардал өндөр байдаг бол боловсруулах үйлдвэрлэлийн технологи ихэвчлэн хуучирсан, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд хэрэглэж байгаа уламжлалт технологи нь эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа зэрэг шалтгаанаар олон улсын зах зээл дээр төдийгүй дотоодын зах зээл дээр бүтээгдэхүүн нь хүчтэй өрсөлдөж чадахгүй байна. Эдийн засгийн шилжилтийн нөлөөгөөр гадаад худалдааны салбарт зарчмын өөрчлөлт гарч, худалдааны түншүүдийн тоо нэмэгдсэн боловч олон улсын тээврийг гүйцэтгэх хязгаарлагдмал бололцооноос хамааран худалдаанд хөрш улсуудын эзлэх хувь өндөр хэвээрээ байна.

Эдийн засагт гадаад худалдааны эзлэх байр суурь өндөр. Доорх зургаас харахад ДНБ-нд эзлэх гадаад худалдааны нийт эргэлт хугацааны дунджаар 103.2 хувь эзэлж байгаа өндөр үзүүлэлт юм.

### Зураг 3. ДНБ ба ГХ-ны нийт эргэлт



Эх үүсвэр: МҮ-ын статистикийн эмхэтгэл

Гадаад худалдааны тэнцэл 1997, 2006 оныг эс тооцвол үргэлж алдагдалтай байсан. Гадаад худалдааны нийт эргэлтийн 61.1 хувь ДХБ-ын гишүүн орнуудтай хийсэн худалдаа, 35 орчим хувийг ОХУ-тай хийсэн худалдаа эзэлж байгаагийн дийлэнх хэсгийг түлш эрчим хүчний импорт эзэлж байна.

Нийт экспортын бараг 70 орчим хувийг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн, нийт импортын бараг 50 хувийг мал амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, амьтны болон ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүн болон эрдэс химиин болон химиийн үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Ойрын ирээдүйд экспортод уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь улам нэмэгдэх хандлагатай байна. Энэ байдал цаашид ч тогтвортой хадгалагдах магадлалтай.

Импортын бүтцээс хараад мал амьтны болон ургамлын гаралтай бүтээгдэхүүний импортыг орлуулах үйлдвэрлэлийг дэмжих, зайлшгүй шаардлагатайгаас бусад химиийн гаралтай бүтээгдэхүүний импортыг хориглох замаар импортын хэмжээг багасгаж улмаар худалдааны тэнцлийг сайжруулах боломжтой.

Хэдийгээр ДХБ-ын зохицуулалтууд худалдаан дахь саад тогторыг багасгахад чиглэгддэг боловч байгаль орчин болон хүнсний аюулгүй байдал, дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулах импортод тарифын бус зохицуулалтуудыг ашиглахыг хэрэг дээрээ зөвшөөрдөг.

### *Дүгнэлт*

Гадаад худалдаанд, тэр дундаа импортод тарифын бус зохицуулалтыг хэрэглэснээр:

- Импортыг орлуулах дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын бодит орлогыг нэмэгдүүлэхэд түлхэц өгнө.
- Гадаад худалдааны тэнцлийг сайжруулна. Энэ нь дотоодын зах зээл дээрх валютын ханшийг тогтвожуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралыг амжилттай даван туулахын тулд хэрэгжүүлэх шаардлагатай зарим арга хэмжээний нэг нь тарифын бус зохицуулалт байж болох юм.